

Сар бүр гаргадаг “Найдвартай эмэгтэйчүүд” залбирлын хуанли 100 хэл дээр орчуулагдсан бөгөөд 110,000 гаруй хүн хамтдаа залбирч байна.



Эмэгтэйчүүдийн сүнслэг байдлын төлөөх залбирал

TWR Women of Hope Португал нь 2007 онд байгуулагдсан бөгөөд өдгөө найман гишүүнтэй баг болон өргөжиж, “Women of Hope” хөтөлбөрийг зургаан FM радиостанц болон олон төрлийн аудио платформоор дамжуулан түгээдэг. Тэд мөн цахим залбирлын үүлзалт зохион байгуулж, эмэгтэйчүүдэд хүрэхийн тулд нийгмийн сүлжээг идэвхтэй ашигладаг. Португал улс католик улс мжлалтай ч сүүлийн үед аажмаар секулярижиж байгаа тул Христийн хайрыг болон итгэлийн мэдээг түгээхийн тулд ашиглаж болох бүх арга хэрэгслээ ашиглахыг хичээж байна.



카카오톡 채널에서 '소망의 여인들' 채널을 추가하시면
매주 월요일에 한국어 기도카드를 받으실 수 있습니다.

даган дуурайж, авралыг тань гэрчлэн ярих хүсэлтэй байх болтугай. (2 Тим. 3:15-17)

5. Хятадын Хуй үндэстний эмэгтэйчүүдийн нийгэм дэх байр суурь доогуур байдаг. Эзэн минь, сайн мэдээ тэдний амьдралд орж, өөрчлөлт авчрах болтугай. (Гал. 3:28)

6. Конгод сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай тулгарч буй Христчин гэр бүлүүд Таныг хүлээн авч, эдгээх, дэмжлэг үзүүлэх зөвлөгөөг хүлээж авах болтугай. (Ром. 12:2)

7. Эзэн минь, Дани улсад байгаа Христчин эмэгтэйчүүд Танаас мэргэн ухааныг гуйж, жинхэнэ үнэнийг худлаас ялгаж чаддаг байж, итгэлдээ бат зогсох болтугай. (Мат. 7:15-16)

8. Эзэн минь, Доминиканы Бүгд Найрамдах Улсад Христчин үйлчлэлд идэвхтэй оролцож буй эмэгтэйчүүд Таны хүч чадал, нигүүлсэлд найдах болтугай. (2 Кор. 12:9)

9. Эзэн минь, Эсватинийн эмэгтэйчүүд сүнслэг авьяас, чадвараа нээн илрүүлж, Танд үйлчилж, гэр бүл, сүм, нийгэм, улс төр, эх орондоо нөлөө үзүүлэх болтугай. (Сур. 31:26)

10. Эзэн минь, нөхрүүддээ хаягдаж, ганцаараа хүүхдээ өсгөж буй Этиопын залуу ээжүүдэд хүч чадал, итгэл найдвар өгөөч. (Иса. 40:31)

11. Финландын олон залуу эмэгтэйчүүд сүнслэг байдлыг хайдаг ч Христээс өөр зүйлд цагаа зарцуулан эрэн хайж байна. Эзэн минь, удирдагчдад эдгээр эмэгтэйчүүдийг Тан руу хөтлөх мэргэн ухаан өгөөч. (Мат. 5:16)

12. Бурхан минь, Германд байгаа цагаач эмэгтэйчүүд Есүсийн тухай сонсож, Герман чуулгануудаас сүнслэг өсөлтийн урам зориг авах болтугай. (Ром. 10:17)

13. Эзэн минь, Индонезийн итгэгчид террорист халдлагад өртсөн ч итгэлдээ тууштай байх хүч чадал өгөөч. (1 Кор. 15:58)

14. Эзэн минь, Японы Христчин эмэгтэйчүүд Таныг таньж, итгэлээрээ төлөвшиж, Есүс шиг болохын төлөө сүнслэг үр жимсийг бий болгох болтугай. (Еф. 4:11-16)

1. Эзэн минь, Албани улсын шинэ итгэгчид өөрсдийн орон нутгийн чуулганд суралцахдаа Таны дотор итгэлээрээ төлөвшин хөгжих болтугай. (Мат. 28:19)

2. Бурхан минь, итгэлээрээ хавчигдаж буй Бенин улсын Христчин эмэгтэй удирдагчид Таныг түшиж, зоригтой, хүчтэй байх болтугай. (2 Тим. 3:12)

3. Эзэн минь, Ботсвана улсад Христэд итгэгчид Таны хайраар дүүрэн нөхөрлөлийг мэдрэхэд саад болж буй шашны хууль ёсны үзлийг болон хүчийг эвдэж өгөөч. (2 Кор. 10:4-5)

4. Аав аа, Бразилийн Христчин эмэгтэйчүүд Таныг болон Таны Үгийг гүнзгий таньж, Есүсийн амьдрал, сургаалийг

15. Эзэн минь, Солонгосын эмэгтэй пасторууд өдөр бүр Тантай уулзах цаг гаргаж, амьдралынхаа үлгэр жишээгээр бусдыг удирдах болтугай. (Еф. 6:10)

16. Бурхан минь, Монголын Христчин эмэгтэйчүүд Таны Үгийн дагуу үр хүүхдүүдээ сүнслэг төлөвшилд хүргэж, Есүсийг жинхэнэ дагагч болгон бэлтгэх болтугай. (Дед. 11:19)

17. Мьянмар дахь Христэд итгэгчид иргэний дайнтай холбоотой хавчлага ихээр амсдаг. Эзэн минь, тэднийг хамгаалж, аюулгүй байлгаж, Таны оршихуй тэдэнд хүч өгөх болтугай. (Дуулал 91:1-2)

18. Барууны чөлөөт сүмд явах боломжтой Нидерландын олон эмэгтэйчүүд Таныг хүндэтгэх цаг гаргахад хүндрэлтэй байдаг. Эзэн минь, тэд амьдралаа Танд зориулах болтугай. (Иоел. 2:13)

19. Бурхан минь, Норвегийн Христчин эмэгтэйчүүд Таны Үгийг өдөр бүр уншиж, амьдралдаа тусган үйлдэх болтугай. (Дуулал 119:105)

20. Эзэн минь, Папуа Шинэ Гвиней дахь чуулганы удирдагчдыг нэгдмэл байдал, эвлэрлийг өгч, олон нийтийн хоорондох яриа хэлэлцээрийг хөтлөхөд хүчирхэгжүүлээч. (Еф. 4:3)

21. Эзэн минь, Португалийн Христчин эмэгтэйчүүд Таны үгээр өлсөж, Таны Үгийг таньж, Тантай дотно харилцаатай байх болтугай. (Дуулал 19:7-11)

22. Эзэн минь, Румын улсын Христчин эмэгтэйчүүд амьдралаа зөв зохицуулж, Таны хүслээр амьдарч, гэр бүл, сүм чуулган, нийгэмдээ Таны гэрлийг харуулах болтугай. (1 Пет. 3:1-6)

23. Өмнөд Африкийн чуулганууд орчин тойрон дахь хүмүүс, ялангуяа ганц бие ээжүүдэд итгэл найдвар өгөх болтугай. (Фил. 2:4)

24. Эзэн минь, Испанийн итгэгчид Таны өгсөн боломжийг олж харж, бусадтай сүнслэг яриа өрнүүлэхэд туслаач. (Еф. 2:10)

25. Бурхан минь, Танзани арлын эмэгтэйчүүд итгэлдээ бат зогсож, ажилд орохын тулд өөр шашинд орох шахалтад өртөхгүй байх болтугай. (Гал. 5:1)

26. Эзэн минь, Тимор-Лесте дахь сүмийн удирдагчдын удирдах ур чадвар, теологийн боловсролыг хөгжүүлээч. (2 Тим. 2:2)

27. Уругвайд гэр бүлүүд амьдрахын тулд хар тамхи зардаг. Үүнээс болж залуус мөргөлдөөнд өртөж байна. Аав аа, хар тамхины хүчийг устгаж, тэдний нүдийг Таны зам руу нээгээч. (Еф. 6:13-18)

28. Эзэн минь, Вьетнамын цөөнхи Христэд итгэгчдэд итгэлээ бат хадгалж, шахалт, аюул заналаас ангижрах хүч өгөөч. (Иса. 41:10)

Монголын төлөө залбирах сэдвүүд -----

1. Агаарын бохирдол ба эрүүл мэндийн асуудлууд: Цаг агаар хүйтэрч байгаатай холбоотойгоор Монгол Улсад агаарын бохирдол нэмэгдэж, ялангуяа бага насны хүүхдүүдэд ханиад, уушгины хатгалгаа зэрэг өвчлөлд ихэсч байна. Өвдсөн хүмүүс бүрэн эдгэрч, Бурханы хамгаалалтанд байхын төлөө
2. Шүтээнээс эргэх нь: Монголын ард түмэн худал шүтээнээс эргэж, Бурханыг таньж, бүх алдрыг Түүнд өргөхийн төлөө
3. Залуучуудын Засгийн газрыг эсэргүүцэн жагсаж байгаа жагсаал үр дүнтэй байж, амар тайван дотор байхын төлөө

후원안내

국민은행 851-01-0003-724 북방선교방송

최초 입금 후 사무실로 연락주시기 바랍니다.